



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 26 өдөр

Дугаар А/527

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 заалт, "Аймгийн 2024 оны төсөв батлах тухай" 14/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн 2025 оны төсөл, 2026-2027 оны төсөөлөл, хөрөнгө оруулалтын төслийг нэгтгэн хянуулах, орон нутгийн "Брэнд" бүтээгдэхүүн сурталчлахад гарах арга хэмжээний зардалд 7,052,900.00 төгрөгийг хавсралтаар баталж, зарцуулсугай.

2. Тус арга хэмжээнд зарцуулах нийт 7,052,900.00 (долоон сая тавин хоёр мянга есөн зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын захиалагчийн хяналтын зардал дансны 2024 онд батлагдсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээнээс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэгэгч (Д.Эрдэнэбат), Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал) нарт тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Х.БАТБОЛД

8400001 1286

Zah A/527 Kh

Засаг даргын 2024 оны  
07 дугаар сарын 26-ны өдрийн  
А/527 дугаар захирамжийн хавсралт



АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ТӨСВИЙН 2025 ОНЫ  
ТӨСӨЛ, 2026-2027 ОНЫ ТӨСӨӨЛӨЛ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛИЙГ  
ТУШААЖ ХЯНУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДАЛ

Д/д	Үзүүлэлт	Тоо хэмжээ		Нийт төлбөрийн дүн	
1	Томилолт	3 хүн	200000.00	3,000,000.00	
2	Шатахуун (Хо-УБ-Хо)	1700 км		1,142,400.00	
3	Аймгийн брэнд бүтээгдэхүүн	Шийгуа	300 кг	2500.00	750,000.00
		Ааруул	35 кг	35000.00	1,225,000.00
		Бяслаг	10 ш	50000.00	500,000.00
		Шар тос	20ш	14000.00	280,000.00
		Арвайн гурил	20 ш	7000.00	140,000.00
4	Ачааны үнэ	315 кг	500.00	157,500.00	
НИЙТ ДҮН				7,052,900.00	

-oOo-